

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLIX (622)

DOI: 10.22353/ms20254912

ӨВӨР МОНГОЛЫН ИХ СУРГУУЛЬД 2016-2025 ОНЫ ХУГАЦААНД
ХИЙГДСЭН ХЯТАН БАГА ҮСГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ¹

Ван Гуа²

Товч агуулга: 2017 онд хэвлэгдсэн Чингэлтэй нарын “Хятан бага үсгийн тухай дахин судлал” бүтээлд 2016 оноос өмнө хийгдсэн хятан бага үсгийн тухай судалгааны үр дүнг танилцуулж, нягтлан шүүмжилж, үнэлж дүгнэсэн юм. Тус бүтээл хэвлэгдэн гарснаас хойших хугацаанд хятан бага үсгийн судалгаа үргэлжлэн өрнөсөөр, шинэ ололт амжилт гарсаар, шинэ бүтээлүүд нийтлэгдсээр байна. Тиймээс энэхүү өгүүлэлд 2016 оноос 2025 оны хугацаанд Өвөр Монголын Их Сургууль дээр хийгдсэн хятан бага үсгийн судалгааны ажлуудыг нарийвчлан танилцуулж, шинэлэг үр дүнгүүдийг танилцуулахыг зорилго болгов.

Түлхүүр үг: Хятан бага үсэг, 2016 оноос 2025 оны хугацаан дахь үр дүн, Өвөр Монголын Их Сургууль дахь хятан бага үсгийн судалгаа

1. Магистрын судалгааны ажил

2016 оноос 2025 оныг хүртэлх хугацаанд Өвөр Монголын Их Сургуульд хятан бага үсгийн судалгааны хүрээнд Хөгжилт “Хятан хэл хийгээд монгол хэлний нийт дундын үгийн судлал”, Чимэг “Хятан хэлэнд илэрсэн овог аймгийн нэрийдлийн судлал”, Содончанга “Хятан хэлэнд илэрсэн жөү шианы нэрийдлийн судлал”, Яруу “Хятан бага үсгийн төрөл садны нэрийдлийн судлал”, Нарантуяа “Хятан хэлэн дэх хүний нэрийн судлал”, Чансаа “Хятан бага үсгийн аялгас дахь сүүл холбосон үсгүүдийн судалгаа”, Сүмбэр “Хятан хэлний тэмдэг үйлийн судалгаа” зэрэг магистрын судалгааны ажил гүйцэтгэжээ.

Өвөр Монголын Их Сургуулийн магистрант Хөгжилт “Хятан хэл хийгээд монгол хэлний нийт дундын үгийн судлал” гэсэн сэдвээр 2017 онд магистрын зэрэг хамгаалжээ. Тус бүтээлд голдуу өмнө нэгэнт тайлбарлан уншсан хятан бага үсгийн судалгааны үр дүнг үндэслэн хятан хэл ба монгол хэлний нийт дундын үгийг бүртгэн гаргасан байна. Хятан хэлний зарим эгшиг нь монгол

¹ Тус өгүүллийг БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны сангийн төсөв болох “Ляо улсын хааны угсаатны хятан бага үсгийн сурвалж бичгийн тайламж хийгээд үндэстэний соёлын уламжлалын судлал” (20BYU189) сэдвийн хүрээнд гүйцэтгэв.

² Ван Гуа, БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн ахисан түвшний суралцагч.

хэлний /b/ гийгүүлэгчтэй харгалзсан үзэгдэл байгааг гаргажээ. Жишээлбэл: хятан хэлэн дэх 介央 (you-ur) нь монгол хэлний /xabar/ “хавар”, хятан хэлэн дэх 友平 (u'ul) нь монгол хэлний /θbəl/ “өвөл” гэх мэт. Хятан хэлний зарим үгст /g/ гийгүүлэгч гээгдэх үзэгдэлтэй байна. Жишээлбэл: хятан хэлэн дэх 伏岑 (n-ə) нь монгол хэлний [nəgə:] “нөгөө”, хятан хэлэн дэх 土火 (ou-ui) нь монгол хэлний /uge:~ugui/ “үгүй”. Хятан хэлэн дэх зарим үгс нь монгол хэлтэй харьцуулбал үгийн эцсийн /n/ гийгүүлэгч товчлох үзэгдэлтэй байна. Жишээлбэл: хятан хэлэн дэх 达 (ol) нь монгол хэлний /olon/ “олон”. Хятан хэлэн дэх 公反九 (n-m-g) нь монгол хэлний /nimgen/ “нимгэн” нэх мэт. Хятан хэлэн дэх зарим үгс нь үгийн язгуурын хэлбэрээр оршиж байна. Жишээлбэл: хятан хэлэн дэх 罕 (u) нь монгол хэлэн дэх /us/ “ус”, хятан хэлэн дэх 奈 (nai) нь монгол хэлэн дэх /noǰəŋ/ “ноён” гэх мэт. Хятан хэлэн дэх зарим үгст түүнтэй харгалзсан монгол хэлний /s, x, k, ɣ/ гийгүүлэгч гээгдэх үзэгдэл байна. Жишээлбэл: хятан хэлэн дэх 岑奉 (em-ŋ) нь монгол хэлний /amsax/ “амсах” гэх мэтээр харьцуулан авч үзжээ.

2020 онд Өвөр Монголын Их Сургуульд магистрын зэрэг хамгаалсан Чимэгийн “Хятан хэлэнд илэрсэн овог аймгийн нэрийдлийн судлал” гэх бүтээлд голдуу одоо хадгалагдаж байгаа хятан их, бага үсгийн хөшөө чулуу, жич “Ляо улсын түүх”, “Хятан гүрний товч тэмдэглэл” болон хятад чулуун сийлмэл дэх холбогдол бүхий тэмдэглэлтэй уялдуулан, хятан хэлэнд харагдаж байгаа овог аймгийн нэрийдлийг системтэй цуглуулан эмхэтгэж судалсан байна. Яо-нян зу-ү хаан (遥辇阻午可汗 yao nian zu wu ke han)-аас Шэнзун хаан (圣宗 sheng zong) хүртэл овог аймгийн нэрийдлийн тухай нарийн тодорхой танилцуулга хийжээ. Зохиогчоос “Ляо улсын түүх”-д илэрсэн 259 зурвас овог аймгийн нэрийдэл, жич ирэлтийг хүснэгтийн хэлбэрээр системтэй эмхэлсэн бөгөөд “Хятан гүрний товч тэмдэглэл” болон адил цаг үеийн хятад үсгийн хөшөө зэрэг сурвалж бичигт илэрсэн овог аймгийн нэрийдэл жич ирэлтийг эмхэлсэн байна. Өмнөх хүмүүсийн судалгааны үр бүтээлд “Чү те” (楮特 chu te) нь “Чү лү тэ” (初鲁得 chu lu de)-ийг зааж, зохиогч тус овог аймгийн нэрийг илтгэх хятан бага үсэг 朮 𠤎 𠤎 дэх хоёрдугаар үндсэн үсэг 𠤎-ийг (l) буюу (r) гэж дуудлагыг нь сэргээсэн байна. Зохиогч хүний нэр “Ү вэй” (乌隗 wu wei)-ийн хятан бага үсэг 𠤎 𠤎 𠤎 болон “Ляо улсын түүх”-д илэрсэн овог аймгийн нэр “Ү вэй аймаг” (乌隗部 wu wei bu)-ийн дуудлагатай адил, “Ляо улсын түүх”-д илэрсэн овог аймгийн нэр “Тү луй бү аймаг” (突吕不部 tu lü bu bu) болон хятан бага үсгийн материалд илэрсэн хүмүүний нэр “Тү луй бү” 𠤎 𠤎 үсгийн утга нь адилхан гэжээ. Төгсгөлд нь зохиогч хятан их, бага үсгийн материалд илэрсэн 49 зурвас овог аймгийн нэрийдэл, дуудлага, илэрсэн тоо жич ирэлтийн тухтай эмхэтгэн тодорхойлсон байна.

2021 онд магистрын зэрэг хамгаалсан Содончангын “Хятан хэлэнд илэрсэн жөү шианы нэрийдлийн судлал” гэх бүтээлд голдуу “Ляо улсын түүх”-ийг суурь материал болгож, “Хятан гүрний товч тэмдэглэл” ба адил хугацааны хятад хэлний хөшөөний сийлмэлд илэрсэн жөү шианы нэрийдэлтэй уялдуулан, харьцуулсан үсэг бичгийн ухаан ба түүхэн харьцуулсан хэл шинжлэлийн аргыг хэрэглэн,

өмнөх хүмүүсийн тайлбарлан уншсан судалгааны суурин дээр хятан хэлний сурвалж бичигт илэрсэн жөү шианы нэрийдлийг голлон шинжилжээ. Жөү шиан нэг бүрийн түүхийн хувиралт, хятан хэлний сурвалж бичигт илэрсэн байдал зэрэгт бүх талаар задлалт хийсэн бөгөөд өмнөх хүмүүсийн нэгэнт тайлбарласан үр дүнг шалган байцаажээ. Зохиогч хятан бага үсгийн материалд “жөү”-ийг илтгэх хятан бага үсэг хоёр хэлбэрээр илэрчээ гэж тодорхойлж, нэг нь “жөү”-гийн хятан хэлний авиачилсан орчуулга нь 𐎧𐎡 байж, нөгөө нь 𐎧 болно. Зохиогчийн үзэхээр “жөү”-ийг илтгэх хоёр хэлбэр нь хэрэглэх аргын талаар зөрөөтэй, хятан бага үсэг 𐎧𐎡 нь олонх байдалд “жөү”-ийг илтгэж, 𐎧 нь “орон нутгийн” гэснийг илтгэж, иймээс хэрэглэх хүрээ хэвчээ нь улам өргөн буюу “жөү”-ийг илтгэхээр барахгүй бас “хот” болон “шиан”-ыг илтгэнэ гэж дүгнэжээ.

2021 онд магистрын зэрэг хамгаалсан Яруугийн “Хятан бага үсгийн төрөл садны нэрийдлийн судлал”-д голдуу хятан бага үсгийн материалд илэрсэн, нэгэнт тайлбарлан уншсан төрөл садны нэрийдлийг системтэй эмхэлж, 37 төрөл садны нэрийдэл, жич түүний нэмэлт бүрэлдэхүүний үсгийн хэлбэрийг эмхэтгэн гаргасан бөгөөд эмхэтгэн гаргасан төрөл садны нэрийдлийг эрэгтэй төрөл садны нэрийдэл, эмэгтэй төрөл садны нэрийдэл, жич эрэгтэй эмэгтэйд нийдэм хэрэглэх төрөл садны нэрийдэл гэж хувааж, тус бүрд нь тайлбарласан байна. Зохиогч хятан хэлэнд хоёр, жич хоёроос дээш төрөл садны дуудлага нь төрөл садны дуудлагыг илтгэх үзэгдэл оршиж байхыг ажиглаж олов. Жишээлбэл: 𐎡 нь “ах”-ыг зааж, 𐎡𐎡 нь “аав”-ыг зааж, 𐎡𐎡𐎡 нь “авга”-ыг заана. 𐎡𐎡 нь “дүү”-г зааж, 𐎡𐎡𐎡 нь “өвөө”-г зааж, 𐎡𐎡𐎡𐎡 нь “авга өвөө”-г заадаг. Энэ бол хятан хэлний төрөл садны нэрийдэлд үргэлж харагддаг үг бүтээх хэлбэр болно гэжээ.

2023 онд магистрын зэрэг хамгаалсан Нарантуяагийн “Хятан хэлэн дэх хүний нэрийн судлал” бүтээлд зохиогч өмнөх үеийн судалгааны үр дүнд суурилж, “Ляо улсын түүх”, “Хятан гүрний товч тэмдэглэл” зэрэг түүхэн сурвалж, жич хятад хэлний хөшөөний холбогдол бүхий тэмдэглэлтэй уялдуулан, одоо болтол нийтлэгдсэн хятан бага үсгийн сурвалж бичигт хятаны хүний нэрийг тайлбарлан уншсан байдалд системтэй судалгаа хийжээ. Зохиогч, тус судалгаагаараа нэг хятан хүн олон нэртэй байх үзэгдэл, нэр халах үзэгдэл, жич нэр холбох шинэ үзэгдлийг илрүүлэн гаргаж, өмнөх үеийн судалгаанд нэгэнт тайлсан хятан их бага үсгээрх хүний нэрийг системтэйгээр эмхэтгэн ангилж, хятан бага үсгээрх 400 хүний нэр, хятан их үсгээрх 100 хүний нэрийг хүснэгтлэн жагсаажээ.

2024 онд магистрын зэрэг хамгаалсан Чансаагийн “Хятан бага үсгийн аялгас дахь сүүл холбосон үсгүүдийн судалгаа” бүтээлд голдуу өмнөх үеийн эрдэмтдийн судалгааны үр дүнд суурилан, хятан бага үсэг дэх сүүл холбосон үсгийг хураангуйлан, дахин холбоц үсгийн авианы харьцаагаар удиртгал болгож, хятан бага үсгийн үндсэн үсгийг аль олон шалган батлах ба шинээр хайх судалгааг хийжээ. Зохиогч хятан бага үсгийн бичээсийг хураангуйлж, таван зүйлийн хэлбэрт хуваажээ. Нэгдүгээрт: хөшөө чулуу бүрэн бүтэн, өгүүлбэрийн бичээс, хоёрдугаарт: хөшөө чулуу бүрэн бүтэн, хагас өгүүлбэрийн бичээс, гуравдугаарт: хөшөө чулуу бүрэн бүтэн, өгүүлбэрийн ялгалгүй бичээс, дөрөвдүгээрт: хөшөө

чулуу эрэмдэг, өгүүлбэрийн бичээс, тавдугаарт: магадлахын аргагүй гэж хуваасан байна. Зохиогч хөшөө чулууны бичээсийг судлахаар дамжин 6 бүлэг холбоц үндсэн үсэг болон 25 холбоц үндсэн үсэг илрүүлж, бас хятан хэлэн дэх холбоц солих үзэгдлийг тодруулжээ. Үүний суурин дээр, зохиогч холбоц холбох жам хуулийг ашиглан өмнөх хүмүүсийн үндсэн үсгийн сэргээсэн дуудлага нь оновчтой гэдгийг шалган баталсан байна. Жишээлбэл: 𠬞/aw/~𠬞/tʰaw/ 𠬞/ew/~𠬞/tew/~𠬞/tʰew/ 𠬞/um/~𠬞/tʰum/ 𠬞/al/~𠬞/tʰal/ 𠬞/ 𠬞/~𠬞/tɔr/ 𠬞/ur/~𠬞/mur/ зэрэг байж, үндсэн үсгийн дуудлагыг залруулсан нь 𠬞/he/→/kʰaj/ 𠬞/uej/→/uaj/ 𠬞/you/→/kʰaw/ 𠬞/ta/→/taw/ 𠬞/tʰu/→/tʰew/ 𠬞/en/→/uen/ 𠬞/pɔt/→/par/ 𠬞/sær/→/sa(j)ir/ 𠬞/tʃur/→/tʃir/ 𠬞/yul/→/qul/→/kʰɔr/ 𠬞/(a)pʰɔ/→/pʰɔr/ 𠬞/ful/→/tʃur/ зэрэг байж, зохиогчийн шинээр уншсан үсэг гэвэл 𠬞/(?p-)-aj/ 𠬞/(?t-)-ar/ 𠬞/(?ni-ur)/ 𠬞/-aj/ 𠬞/-en/ 𠬞/-al/ 𠬞/-ar/ 𠬞/-er/ 𠬞/-ɔr/ зэрэг үндсэн үсэгийн бүхэл цогцод дуудлага буюу холбоцын хэсгийн дуудлага-г сэргээсэн бий.

2025 онд магистрын зэрэг хамгаалсан Сүмбэрийн “Хятан хэлний тэмдэг үйлийн судалгаан” бүтээлд зохиогч урьдах хүмүүсийн судалгааны үр дүнд суурилан, түүхэн харьцуулсан хэл шинжлэл, бүртгэлийн ухаан, харгуулан байцгаах ухаан зэрэг судалгааны аргаар хятан хэлний тэмдэг үйл үгийг задлан судалжээ. Тус бүтээлд голдуу хятан хэлний тэмдэг үйл үгийн нөхцөлийг системчлэн авч үзжээ. Зохиогчийн дурдан гаргасан хэдэн үзэлт гэвэл: Хятан бага үсэг 𠬞肉(o-on) нь эм хүйст хэрэглэгдэж, 𠬞北(o-or) нь эр хүйст хэрэглэгдэж, энэ нь харилцан эсрэгцэн орших тэмдэг үйл үгийн нөхцөл болно. Бас хятан бага үсэг 𠬞(an)/ 𠬞出(a-an) (эм хүйс) болон 𠬞(ar)/ 𠬞本(a-ar) бол харилцан эсрэгцэн орших тэмдэг үйл үгийн нөхцөлийн онцгой хэлбэр болно гэжээ. Мөн, хятан бага үсэг 𠬞肉(o-on), 𠬞北(o-or) нь голдуу оны цол, хүний нэр дээр хэрэглэх тусгай нэр томьёо болно гэжээ. Түүнчлэн, тэмдэг үйл үгийн нөхцөл 𠬞艾(a-aju) 𠬞(aju) нь олон тоог илтгэж, үүнтэй харгалзсан ганц тоог илэрхийлэх нь 𠬞(an)/ 𠬞出(a-an) (эм хүйс), 𠬞(ar)/ 𠬞本(a-ar) (эр хүйс) болно. Зохиогч тэмдэг үйл, үг жич нөхцөлийг судлахын хамт хоёр нэр үгийн олон тооны нөхцөлийг судалж, хятан бага үсэг 𠬞𠬞(em-ci) “олон зам” нь 𠬞𠬞(em-er) нь “зам”-ын олон тооны хэлбэр гэж, хятан бага үсэг 𠬞𠬞(sau-ji) “олон цэрэг” нь 𠬞𠬞(sau-ur) “цэрэг”-ийн олон тооны хэлбэр гэжээ. Хятан бага үсгийн 𠬞(ci) болон 𠬞/𠬞/𠬞(ji) нь хятан хэлэнд нэр үгийн олон тооны нөхцөлийг илтгэнэ гэжээ. Үүнээс гадна, хятан хэлний хүйсийн зохицлын жам хуулийг ашиглан хятан бага үсэгт 𠬞 “тэнгэр”, 𠬞𠬞(g-úr) “улс”, 𠬞𠬞(n-ar) “нар”, 𠬞(bod) “бие” зэрэг нэр үгийн хүйсийн ялгалыг илрүүлжээ. “Ашид, үүр”-ийг илтгэх үндсэн үсэг 𠬞-ийн дуудлагыг /eur/ гэж сэргээж, хятан бага үсэг 𠬞𠬞𠬞𠬞 нь 𠬞-аар язгуур болгосон тэмдэг үйл үг гэж үзэж, утга нь “мөнхрүүлэх” гэж магадлажээ. Үүний хамт тэмдэг үйл үг 𠬞𠬞𠬞𠬞𠬞 нь “үзүүлэх, мэдүүлэх” гэснийг илтгэж, 𠬞𠬞 𠬞𠬞𠬞𠬞 нь хятад хэлэн дэх “жы гао” (制造 zhi gao)-тай харгалзаж зэрэг тушаалын нэр “жы жы гао” (知制造 zhi zhi gao)-ийн хятанчилсан илэрхийлэл гэжээ.

2. Докторын зэрэг горилсон бүтээл

2017 онд Өвөр Монголын Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан Зүрхээгийн “Шинээр илрүүлсэн хятан бага үсгийн Е луй тянь тайшийн хөшөөний бичиг” нэг сэдэвт бүтээлд Е луй тянь тайшийн хөшөөний бичгийг системтэйгээр судалж, өмнөх эрдэмтдийн судлаагүй байсан 39 хятан үгсийг тайлбарлан уншжээ. Хятан бага үсгийн 生天 нь “овог төрлийн” гэх утгыг зааж, 中文旁 支焚也 нь “сул намтар”, 未本 未化当有 нь “эхний үсэг”-ийг зааж, 仇 нь “жуу бичиг”, 全为本引出 全考未 нь хүний нэр “Сала шюэ не чы” (撒刺・斜涅 赤 sa la-xie nie chi), 屋为火 нь “чулуу”, 丹存力 нь “элсэн урсгал” (流沙 liu sha), 去卡 нь “өвс”, 去卡又 列扎和 нь “Сайн Цаочуань” (好草川 hao cao chuan), 又及 нь “мод, 灰伏 нь хүний нэр “Сү-йин” (苏隐 su yin), 全去升伏 нь “эцэс”, 支伏升伏 нь “бууж өгөх”, 主 нь “салхи”, 今文存全 нь “өмнө”, 全本坐当 нь “салах”, 穴出 нь “очих”, 未本为出 нь “урсах”, 失谷 нь хүний нэр “Y-e” (吾也 wu ye), 今久比 нь “бүхэл, дунд”, 万本为央 нь “Жуай ла жы” (拽刺之 zhuaì la zhi), 又北欠 нь хүний нэр “Мо лу гү” (磨鲁古 mo lu gu), 今生方升弱和 нь “холбогдох” (交加 jiao jia), 介炙 нь “элс”, 丙全 нь “адугуу хариулах, адугуу сүрэг”, 今丙卡比 нь “Фань ши” (蕃息 fan xi), 又及全和 нь “сүргээр маллах”, 尺平升失 болон 尺平力 нь “харах, үзэх”, 公金 нь “найм”, 去卡 何急 нь нэг зүйлийн эм “өвсөн шөл”, 尺平岑比 нь “өгөх”, 今文又关和 нь “томилох”, 万困欠 нь хүний нэр “Юй лү дү гү” (馮盧睹姑 yu lu du gu), 丹为方 нь уулын нэр “Дали” (达离 da li), 未力 нь “зээ хүү” (外甥 wai sheng), 平 нь “уул”, 几关 全並 公及 нь хүний нэр “Жи сянь нү” (吉祥奴 ji xiang nu)-ийг тус бүр илтгэнэ гэжээ. Зохиогч бас 10 хятан бага үсгийн дуудлагыг сэргээжээ. Үүнд: хятан бага үсэг 田(bot~bod), 全(ir), 因(qay), 止(maut~mod), 止(kus~hus), 母(əl~il), 中(bir~bur), 丰(yul), 仇(ku), 辱(dolo'e) гэсэн дуудлагыг тус тус сэргээсэн байна. Зохиогч мөн хоёр шинэ үндсэн үсгийн хэлбэрийг ялган тодолсон бөгөөд хөшөө бичгийн бүх агуулгыг латин үсгээр буулгажээ.

2019 онд докторын зэрэг хамгаалсан Жао Хасгоогийн “Шинээр илрүүлсэн хятан бага үсгийн Е луй тие бу тайшийн хөшөө (耶律贴不太师墓志碑 ye lü tie bu tai shi mu zhi bei)-ний судлал” нэг сэдэвт бүтээлд уг хөшөөний бичээсийг электрончилж, латин үсгээр буулгажээ. Судалгааны явцад шинэ үндсэн үсгийг илрүүлж өмнөх эрдэмтдийн судалгааны суурин дээр хэдэн хятан их, бага үсгийн дуудлагыг сэргээв. Зохиогч хятан бага үсэг 由-ийг (pu) гэж, 𠂇-ийг (lis) гэж, 𠂇-ийг (po) гэж, 𠂇-ийг (k) гэж, 𠂇-ийг (yos) гэж, 𠂇-ийг (pæt) гэж тайлбарлан уншсан байна. Хятан их үсэг 吏-ийг (pu) гэж, 𠂇-ийг (her) гэж, 𠂇-ийг (p`ang/fang) гэж, 𠂇-ийг (mau) гэж, 𠂇-ийг (p`f) гэж, 𠂇-ийг (sian) гэж дуудлагыг сэргээжээ. Мөн гуч гаруй хятан бага үсгийг тайлбарласан нь: 公企 雨安 𠂇 нь “дотоод цэрэг”, 公企 𠂇 𠂇 力 нь “үүрд”, 𠂇 由 нь хүний нэр “Те бү” (贴不 tie bu), 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “хуяг”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “хатгах, нэвтлэх, харвах”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “өрсөлдөөнд оролцох”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “сүр жавхлант”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь овог аймгийн нэр “Жари” (扎里部 zha li bu), 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “Шү бао ли” (术保里 shu bao li), 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “нэр алдартай, гэрэл цацрангуй”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “нэмэх”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 “малтлагын холбоо” (掘联 jue lian), 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “өмнө тал”, 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 нь “муж руу буцах” (归州 gui zhou), 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇 𠂇

伏升安 нь “эрүүний хэсэг” (颌的部 xie de bu), 令亦关 劣平中 伏升安 нь “Тагури туру бубу” (塔古里突吕不部 ta gu li tu lü bu bu), 欠平 公秀 伏升安 нь “Ү гу не өргөс хэлтэс” (乌古涅刺部 wu gu nie la bu), 今业 公灾 нь “хөдөөгийн эмэгтэй”, 失 нь “ёслол”, 公中 化列 冬 公 нь “сайн, буянсаг”, 欠无 公 公 нь “болгоомжлох”, 止 为 丑 хүний нэр “Па ба” (杷八 pa ba), 目 冬 冬 冬 нь “цайлган сэтгэлтэй”, 金 又 нь “адилхан”, 欠 北 欠 欠 秀 令 仕 坐 北 нь “харангуй болох”, 令 失 нь “дуу”, 考 公 нь “ойртох”, 欠 今 公 中 нь “үе”, 雨 行 ； 午 当 亦 当 “уйтгартай төгсөх” (郁郁而终 yu yu er zhong), 亦 当 нь “явах”-ыг тус тус илтгэнэ гэж үзсэн байна. Хятан бага үсгийн 只 失 只 公 只 安 夫 关 夫 公 及 公 нь туслах үйл үг болохыг тодорхойлжээ.

2019 онд докторын зэрэг хамгаалсан Пэн Даруухан “Хятан бага үсгийн *Шяо ди ле лань жүний хөшөөний бичиг* болон *Е луй а му ха нянь зы-ийн гэрээлгийн хөшөөн бичиг*” (萧迪烈郎君墓志 xiao di lie lang jun mu zhi, 耶律阿姆哈娘子墓志 ye lü a mu ha niang zi mu zhi) нэг сэдэвт бүтээлд хятан хэлний 26 үгийг тайлбарлан уншихын хамт цөөнгүй хятан бага үсгийн дуудлагыг сэргээжээ. Хятан бага үсгийн сурвалж бичгийн хэлний материалын хөмрөгтэй уялдуулан хятан хэлний дахих тооны үгсийн нэмэлт бүрэлдэхүүний авианы хэлбэрийг хураангуйлан дүгнэж, Агүжы (阿古只 a gu zhi)-ийн хүний нэрийг шалган нягталж, Агүжы-ийн хөвүүн Ан туань (安团 an tuan)-ын удам угсааг эмхэтгэн гаргаж, “Ляо улсын түүх” дэх зарим алдаа буруу ба дутагдлыг нөхвөрлөжээ. Зохиогч өмнөх судалгаа ба холбогдол бүхий түүхэн материалыг үндэслэн хятан бага үсгийн үндсэн үсгийн дуудлагыг сэргээжээ. Зохиогч, Ан туань (安团 an tuan)-ийн нөгөө нэг нэр нь 爻非火伏 байж, хятан сурвалж бичиг дэх “Мигури” (迷古里 mi gu li), “Мигуд” (迷古德 mi gu de), “Мигунин” (迷古宁 mi gu ning)-тай харгалзана гэж, үүнээс үндсэн үсэг 非-д (ku) дуудлагатай гэжээ. Зохиогчийн үзэхээр хятан хүний нэр 爻当 болон 爻岑 нь хятан сурвалж бичиг дэх “Шюй нянь” (虚擎 xu nian), “Шюй ле” (虚列 xu lie)-тэй харгалзаж, үндсэн үсэг 爻 болон 爻-д (hiu) дуудлага хаджээ. Хүний нэр 全文考 爻-ийг “Шянь хэ” (仙河 xian he) болохоор дамжин үндсэн үсэг 爻-ын дуудлага (ya) гэж сэргээжээ. Харьцуулсан судлалаар дамжин, зохиогч “Ту Тай авгын гашуудлын бичиг” (故太叔祖哀册)-ийн 25 дугаар мөрд илэрсэн 全文考 爻 屈力 山 爻坐 нь “хөх чулуу шар шороо”-г илтгэж, 爻坐 нь “шороо”-г илтгэж, үндсэн үсэг 坐 нь (ro) болох магадлалтай гэж таамаглав. Зохиогч хүний нэр 爻立安 “Шуан гү” (双古 shuang gu) болон 立充关 “Пи ди” (匹敌 pi di)-ийг тайлбарлан уншиж, үндсэн үсэг 立 нь (on) гэж, 充 нь (d) гэж дуудагыг сэргээсэн байна. Үүнээс гадна зохиогчийн тайлбарлан уншсанаар хятан бага үсэг 力乃 万爻 九亦 нь “Нань ян жүнь” (南阳郡 nan yang jun)-ийг илтгэж, 爻 亦 旁 火 央 化 爻 нь “Тянь мин жы” (天命至 tian ming zhi)-ийг илтгэж, 旁 平 立 本 нь “салах” гэснийг илтгэж, 万 本 中 нь уулын нэр “Жуай ла” (拽刺 zhuai la) гэж, 爻安 нь өгөх оршихын тийн ялгалыг илтгэж, одоо нэгэнт тайлбарлан уншсан өгөх оршихын тийн ялгал 万安-тай харгалзаж, энэ нь улмаар дундад эртний монгол хэлний (tor, dor)-той адилавартай гэж тодорхойлжээ.

2024 онд докторын зэрэг хамгаалсан Бай Юань Мингийн “Шинээр олдсон хятан бага үсгийн Е Люй Юй Гү Линь тайшийн хөшөөний бичгийг тайлбарлан

унших нь” нэг сэдэвт бүтээлд тус хөшөөний үсгийн хэлбэр болон 下, 泊, 市 гэсэн гурван шинэ үсгийн хэлбэрийг шалган гаргаж, хятан бага үсэг 卞, 弱 нь үндсэн үсгийн бичлэг ондоо хувилбар болохыг нотолжээ. Мөн, хятан бага үсэг 而-ийг (du) гэж, 卩-ийг (tʃ~tʃ) гэж сэргээж, 下-ийг (teyr) гэж, 泊-ийг (i) гэж, 彳-ийг (s) гэж, 𠂇-ийг (qa) гэж, 王-ийг (ri) гэж тус тус сэргээжээ. Хятан хэлний хэл зүйн талаар зохиогч үндсэн үсэг 九 болон 𠂇 𠂇 нь олон тооны нөхцөл болж, үндсэн үсэг 𠂇 нь заахын тийн ялгалыг илтгэх болох мөртөө харьяалахын тийн ялгалыг илтгэнэ. Үндсэн үсэг 𠂇 нь өгөх оршихын тийн ялгал болохыг баталж, үүгээр дамжин 𠂇 𠂇 нь гарахын тийн ялгал болохыг судлан гаргасан ба үндсэн үсэг 𠂇 болон 𠂇 нь өгөх оршихын тийн ялгал гэж, 𠂇 𠂇 нь дэс тооны дагавар гэж, 𠂇 нь тэмдэг үйл үгийн нөхцөл гэж, үндсэн үсэг 𠂇 нь давтамжийн тооны нөхцөл гэх зэрэг шинэ үзэл баримтлалыг дурджээ.

Лавлалт болгосон материал:

清格尔泰、吴英喆、吉如何. (2017). 契丹小字再研究. 呼和浩特:内蒙古大学出版社.
呼格吉乐图. (2017). 契丹语与蒙古语共同词汇研究. 内蒙古大学博士学位论文.
其木格. (2017). 契丹文所见部族名称研究. 内蒙古大学硕士学位论文.
曹旦长嘎. (2021). 契丹文所见州县名称研究. 内蒙古大学硕士学位论文.
雅茹. (2021). 契丹小字亲属称谓研究. 内蒙古大学硕士学位论文.
娜仁图雅. (2023). 契丹文所见契丹人名研究. 内蒙古大学硕士学位论文.
钦飒. (2024). 契丹小字铭文韵字研究. 内蒙古大学硕士学位论文.
孙布勒. (2025). 契丹语形动词研究. 内蒙古大学硕士学位论文.
吉如何. (2017). 新发现契丹小字《耶律天你太师墓志铭》研究. 内蒙古大学博士学位论文.
赵哈申高娃. (2019). 新发现契丹小字《耶律贴不太师墓志碑》研究. 内蒙古大学博士学位论文.
彭鞞茹罕. (2019). 契丹小字《萧迪烈郎君墓志》与《耶律阿姆哈娘子墓志铭》. 内蒙古大学博士学位论文.
白原铭. (2024). 新近发现契丹小字《耶律于骨邻太师墓志铭》释读. 内蒙古大学博士学位论文.

Abstract

Published in 2017, Further Research on Khitan Small Script not only systematically and comprehensively collated the interpretation results of the Khitan small script up to 2016 but also conducted in-depth analysis and commentary on the interpretation process of this script. Since the book's publication, new breakthroughs and accomplishments have continued to emerge in the field of Khitan small script research. This paper intends to adopt literature research and inductive analysis methods to comprehensively sort out and summarize the achievements made by Inner Mongolia University in Khitan small script research from 2016 to 2025, with a focus on the latest research progress. By presenting a comparative analysis of different research findings from Inner Mongolia University and potential paths for comparative studies, it aims to provide references for relevant researchers. This holds significant academic value and practical significance for deepening the study of the Khitan small script and promoting the further development of Khitan language research.

Key words: Khitan small script, research review, year 2016-2025